



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/882

Ховд

Хөтөлбөр хэрэгжүүлж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ховдын тарвас” брендийн нэр хүндийг хамгаалах, сайжруулах, анхаарах асуудлууд сэдэвт хэлэлцүүлэгт 8,150,000 төгрөгийг зарцуулж, төсвийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 8,150,000 (найман сая нэг зуун тавин мянга) төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 7.8 Ховдын тарвас, Булганы алимыг газар зүйн заалттай болгох судалгааны ажлын заалтаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн), Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батнасан) нарт зөвшөөрсүгэй.

3. Журмын дагуу хэрэгжилтийг хангаж, хуулийн хүрээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Х.БАТБОЛД



8400001 2131

Zah A/882 Ba